



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/287.

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар тогтоолын 1.3.1 дэх зорилт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургуульд шаардагдах 14.000.000 (арван дөрвөн сая) төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулах эрхийг Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургууль (Г.Чулуунцэцэг)-т шилжүүлсүгэй.

2.Холбогдох хууль, журмын дагуу эрх үүргийг хэрэгжүүлж, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургууль (Г.Чулуунцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

